175

БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 .оны 03 дугаар сарын 27.-ны өдөр | Дугаар А/76 | Багануур

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

“Багануурын дулааны станц” ТӨХК-ийн хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. “Багануурын дулааны станц” ТӨХК-ийн эд хөрөнгийг бусдад шилжүүлэх журмыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Журам батлагдсантай холбогдуулан байгууллагын нийт ажилтнуудад танилцуулахыг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга/Ч.Ариунбаатар/-д, дээрх журмыг мөрдөж ажиллахыг байгууллагын нийт ажиллагсдад үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.ГАНБААТАР

Багануурын дулааны станц ХХК

Tushaal-2017

176

"Багануурын Дулааны станц" ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2017 оны 03 сарын
27 өдрийн А/76 тоот тушаалын хавсралт

ЭД ХӨРӨНГИЙГ БУСДАД ШИЛЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Зорилго

Компаний эд хөрөнгө хариуцагч нь өөрийн нэр дээрх бүртгэлтэй эд хөрөнгийг компаний өөр ажилтанд шилжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Эд хөрөнгийг шилжүүлж өгөх

2.1 Дараах тохиолдолд эд хөрөнгийг өөр ажилтанд шилжүүлнэ.

- Тухайн эд хөрөнгө хариуцагч нь өөрийн хүсэлтээр болон компаний удирдлагын зүгээс хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгон ажлаас чөлөөлсөн тохиолдолд
- Ажил, ажлын байрны шаардлагаар эзэмшлийг өөр ажилтанд шилжүүлэх
- Компанидаа өөр ажлын байранд шилжсэн болон ажил албан тушаал хавсран, орлон гүйцэтгэх үед
- Өөрөө хэрэглэхгүй, илүү байгаа эд хөрөнгийг бусдад шилжүүлэх

2.2 Эд хөрөнгийг шилжүүлэхдээ түүний тоо ширхэгийн дагуу бүрэн хүлээлгэж өгнө.

2.3 Хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгон ажлаас чөлөөлөгдсөн этгээд өөрийн нэр дээрх эд хөрөнгийг бүрэн шилжүүлсэний дараа эрх бүхий албан тушаалтан түүний тойрох хуудаст тэмдэглэл үйлдэнэ.

Гурав. Эд хөрөнгийг шилжүүлж авах

3.1 Эд хөрөнгийг шилжүүлж авахдаа түүний тоо ширхэг, чанарыг харгалзана. /Шаардлагатай тохиолдолд эд хөрөнгө шилжүүлэх актад тусгайлан тэмдэглэл үйлдэж болно./

3.2 Эд хөрөнгийг шилжүүлж авсан эд хариуцагч нь эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцна.

3.3 Эд хөрөнгийг зориулалтын дагуу албан хэрэгцээнд ашиглах ба бусдад түрээслэх, худалдах түүнээс ашиг олохыг хориглоно.

3.4 Эд хөрөнгийн эвдрэл гэмтлийг харгалзан түүнийг актлах саналыг эрх бүхий албан тушаалтанд гаргаж болно.

Дөрөв. Эд хөрөнгийг бүртгэх

4.1 Шилжүүлж өгсөн, авсан 2 тал эд хөрөнгө шилжүүлсэн актад харилцан гарын үсэг зурснаар эд хөрөнгө шилжсэнд тооцогдоно.

4.2 Эд хөрөнгө шилжүүлсэн актыг нэн даруй тооцооны нягтлан бодогчид хүргүүлж, эд хөрөнгийн шилжилт хөдөлгөөн хийлгэнэ.

4.3 Эд хөрөнгө хариуцагч нь компаниас хийгдэж буй эд хөрөнгийн тооллогод өөрийн хариуцсан эд хөрөнгийг бүрэн хамруулах

Тав. Хариуцлага

5.1 Эд хөрөнгийг шилжүүлэх үед дутсан, алга болсон тохиолдолд эд хөрөнгө хүлээлгэн өгч буй этгээдээс үнийн дүнг тухайн үеийн зах зээлийн ханшаар бүрэн төлүүлнэ.

5.2 Дутсан, алга болсон эд хөрөнгийг ижил төрлийн, элэгдэл, хорогдолгүй эд хөрөнгөөр орлуулж болно.

5.3 Энэхүү журмаар зохицуулсан харилцааг зөрчсөн тохиолдолд компаний “Хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу хариуцлага хүлээлгэх болно.